

Өгүүлбэрийн цөм бүтэц

Өгүүлбэр нь үйл явдлыг илтгэдэг бөгөөд үйл явдал нь юм ба түүний хөдлөлөөс бүтдэг. Юм нь жинхэнэ нэрээр, хөдөлгөөн нь үйл үгээр илэрдэг.

Өгүүлбэрийн цөм утгыг өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүн, шууд тусагдахуун зэрэг гол гишүүд бүрдүүлдэг .

Дэлгэрүүлэгч гишүүд нь гол гишүүний утгыг нэмэн дэлгэрүүлэх үүрэгтэй.

# Цөм өгүүлбэр

```
graph TD; A[Цөм өгүүлбэр] --> B[2 бүрэлдэхүүнт цөм өгүүлбэр]; A --> C[3 бүрэлдэхүүнт цөм өгүүлбэр]; B --- D[Үйл үг нь эс тусах  
Жишээ нь: Шувуу нислээ.]; C --- E[Үйл үг нь тусах  
Жишээ нь: Би зураг зурлаа.]
```

## 2 бүрэлдэхүүнт цөм өгүүлбэр

Үйл үг нь эс тусах  
Жишээ нь: Шувуу нислээ.

## 3 бүрэлдэхүүнт цөм өгүүлбэр

Үйл үг нь тусах  
Жишээ нь: Би зураг  
зурлаа.

Үйл үг ертөнцийн хөдөлгөөнийг тэмдэглэдэг. Хөдөлгөөний цаана ямар нэгэн үйл явдал болдог. Үйл явдал нь өгүүлбэрээр илэрдэг. Тиймээс үйл үг бүрийн цаана өгүүлбэр байна. Тухайлбал 5 үйл үгтэй өгүүлбэрт 5 цөм өгүүлбэр байна гэж үзнэ.

## Жишээ нь:

Тамир мөсөөр хучигдсаны дараа хүйтэн харз жирэлзэн урсана, хүйтэн харз урссанаас болж уур савсана гэсэн өгүүлбэрт 4 өгүүлэхүүн буюу 4 үйл үг байна. Эдгээр үйл үгийн тоогоор цөм бүтэц гарна.

- Тамир мөсөөр хучигдсан
- Харз жирэлзэн урсана
- Харз урссанаас болж
- Уур савсана

2 бүрэлдэхүүнт  
цөм бгүүлбэр

# Өгүүлбэрүүдийн цөм бүтцийг тогтооё

Жишээ нь :

1. Нэгэн хичээлт хүн цохын гэрлээр бичиг ном уншиж байжээ .

Хүн бичиг ном уншиж байжээ.

Тайлбар: “уншиж байжээ” үйл үг нь өмнөх нэр үгээ заахын тийн ялгалын тэг нөхцөлөөр захирч байгаа тул бүрэлдэхүүнт цөм өгүүлбэр болж байна.

2. Насанбатаас хүрээний сонинг сонсож, цаг төрийн байдлын тухай ярилцав.

Сонинг сонсов. \3 гишүүнт цөм өгүүлбэр\

Хүн ярилцав. \ 2 гишүүнт цөм өгүүлбэр \

3. Гэрэл нүдээ цавчлан, Эрдэнээс баярын нүдээ салгалгүй ширтэнэ.

Гэрэл нүдээ цавчлан \ 3 гишүүнт цөм өгүүлбэр \

Гэрэл нүдээ салгалгүй \ 3 гишүүнт цөм өгүүлбэр \

Гэрэл ширтэнэ .

Тайлбар: ширтэх үйлэнд өртөх зүйл нь тэгээр илэрч байгаа учраас 3 гишүүнт цөм өгүүлбэр болж байна.

Бие даан хийх ажил:

Өгүүлбэрүүдийн цөм бүтцийг тодорхойлоорой.

1. Ээжийн минь сэтгэл навчсын гунигаар шуурна.
2. Эх оронд минь намрын салхи үлээнэ.
3. Элс нүүдэллэж говьд тэмээ буйлна.
4. Улирлын өнгөөр тэнгэр нүүнэ.